

БАГШЛАХ БА СУРАЛЦАХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛД

О.Мягмар

МУБИС-ийн Боловсрол Судлалын Сургууль

Omiiqaa@yahoo.com

Ц.Батсуурь МУБИС

Хураангуй.

Энэхүү өгүүлэлд багшлах ба суралцах үйл ажиллагааны талаар орчин үеийн боловсролын сэтгэл судлалд гарч байгаа онол, практикийн шинжтэй зарим асуудлыг тоймлон авч үзэхийг зорилоо. Үүнд орчин үеийн сургалтын мөн чанар, онолын загварт тулгуурласан харьцуулалт, багшлах ба суралцах үйлийн онцлог, холбоо зэргийг товч авч үзлээ. Сургалтын нийгэм сэтгэл зүйн мөн чанар, идэвхтэй, бүтээлч шинжийг тодруулан тайлбарласнаараа сурах арга барил, технологийн шинэчлэлийг арга зүйн хувьд боловсронгуй болгоход багш сурган хүмүүжүүлэгчдэд тус дөхөм үзүүлэх юм.

Түлхүүр үгс:

Багшлах ба суралцах үйл ажиллагаанд гарч байгаа өөрчлөлт, орчин үеийн сургалтын мөн чанар, багшлах ба суралцах үйлийн талаарх онолын чиг хандлагууд;

Сургалтын орчин үеийн үзэл баримтлал нь доорх хоёр үндсэн итгэл үнэмшилд тулгуурлан шинэчлэгдэж байгаа юм. Нэгдүгээрт, сургалт бол сэргээн санах үйл биш харин зохион бүтээх шинжтэй бүтээлч үйл ажиллагаа юм. Хоёрдугаарт, сургалт нь мөн чанарынхаа хувьд нийгэм, соёлын шинжтэй, хүмүүсийн хоорондын харилцаа учраас нийгмийн болон нөхцөл байдлын хүчин зүйлсийн нөлөө маш чухал үүрэгтэй. Танин мэдэхүйн үйл ч гэсэн ийм шинжтэй юм.

Эдгээр итгэл үнэмшилд тулгуурлан багшлах ба суралцах үйл ажиллагааны талаарх ойлголтод доорх өөрчлөлтүүд гарч байна:

- Сургалтын нийгмийн болон нийгэм -Хэл шинжлэлийн мөн чанарыг онцлон анхаарах
- Ухаарч ойлгох, асуудал шийдвэрлэх, үзэл баримтлалд гарч байгаа өөрчлөлт зэргийг мэдлэгийг идэвхгүй цээжлэхээс чухалчлах
- Сургалт бол идэвхтэй, зохион бүтээх шинжтэй, суралцагчийн өөрийн зохицуулалтад тулгуурласан үйл явц мөн гэдэгт итгэх

Ангид явагдаж байгаа үйл ажиллагаа нь амьдралд хэрэглэгдэх зорилго агуулсан, “жинхэнэ” бодит амьдралтай холбоотой зүйл мөн гэдэгт итгэх (Хэзээ хэрэглэгдэх нь тодорхойгүй уламжлалт академик мэдлэг биш)

- Сургалт, мэдлэг, танин мэдэхүй нь мөн чанарынхаа хувьд тухайн нөхцөл байдлаас шалтгаалдаг
- Хувь хүний чадамж бол зөвхөн оюун ухааны үзүүлэлт биш,үүний эх сурвалж мөн чанар бол маш өргөн хүрээтэй олон талтай байдаг.

Сургалтын мөн чанарын талаар гарч байгаа эдгээр өөрчлөлтүүдийг тодруулах үүднээс зарим асуудлыг товч тайлбарлая.

Идэвхтэй, бүтээлч, өргөжин хуримтлагдах сургалт

“Өдөөгч-хариу үйлдэл” гэсэн бихевиорист загвар сургалтад олон зуун жил нөлөөлсний эцэст “Когнитив хувьсгалын эрин үе” 1970-аад оны үеэс эхэлжээ. Гаднаас хэсэг мэдээлэл өгөөд түүнийг эргүүлэн санах замаар сургалт явагддаг гэж үздэг байсан хуучин үзэл үндсээрээ солигдож байна.

“Суралцагч бол бэлэн мэдлэгээр дүүргэх ёстой сав мөн” гэсэн бичигдээгүй зарчмаас татгалзах цаг нэгэнт болжээ. Үүнтэй холбоотой үзэл баримтлалын шинжтэй нэг гол өөрчлөлт бол сургалт нь суралцагчийн өөрийнх нь дотоод мөн чанарт тулгуурлана гэж үзэх болсон явдал юм.

Иймээс сургалтад суралцагчийн дотоод хүчин зүйлүүд нь гадаад хүчин зүйлүүдээс чухлаар тавигдаж байна. Мэдлэгийг бүтээх давтагдашгүй үйл ажиллагаа нь суралцагч нэг бүрийн давтагдашгүй онцлогт суурилна гэж орчин үеийн конструктив сургалтын онолд үздэг (Derry, 1992, Marshall, 1992).

Конструктив сургалт

Сургалт нь суралцагчийн дотоод ертөнцөөс урган гарна. Энэ бол түүний хүсэл тэмүүлэл, идэвх сонирхол, мэдлэг туршлагын хосгүй ертөнц юм. Орчин үед сургалтын эдгээр дотоод хүчин зүйлүүдийг гадаад хүчин зүйлүүдээс илүүд үзэх болсон билээ. Хүүхэд мэдээллийг өөрийн онцлогт тохируулан тусгаж авдаг учраас тэдний бодол төсөөлөл нь өөр хоорондоо ялгаатай байдаг. Суралцагчийн мэдлэг гэдэг бол түүний зохион бүтээсэн ертөнц юм.

Суралцагчийн дотоод нөөцөөс урган гадагшлан тэлэх сургалт гэдэг нь түүний идэвх, сонирхолд тулгуурлана гэсэн үг. Сургалтын сэдэл, танин мэдэх сонирхол гэх зэргээр бид олонтой бичиж онцлон тэмдэглэдэг. Танин мэдэхүйн баясалд автан мэдлэгт шунан дурласан хүүхэд бол шинжлэх ухааны нээлтийг улайран хийж байгаа эрдэмтэнтэй адил юм. Зөвхөн өөрөө хүсэж сонирхсон хүн л ингэж улайрч чаддаг. Суралцагч мэдлэг эзэмшихийг өөрөө хүсэж байх нь чухал. Тэрээр багштайгаа идэвхтэй хамтран ажиллах явцдаа тухайн мэдлэг өөрт нь хэрэгтэй гэдгийг ухаарч, түүнийг амьдралдаа ашиглаж чадна гэсэн итгэлтэй байх нь сургалтын нэг чухал нөхцөл мөн. Сургалтын сэдэл ба танин мэдэх сонирхлын талаар төрөл бүрийн онолууд байдаг. Энд маш энгийн атлаа багш нарын өдөр дутам анхаарвал зохих нэг асуудлыг сургалтын идэвхт шинжийн эх сурвалж болгон үзсэнийг онцлон дурдъя.

Идэвхтэй сургалт

Сургалт нь суралцагч бүрийн хувьд утга учиртай байх ёстой. Эзэмшиж байгаа мэдлэгийнхээ утгыг ухаарч ойлгох, өөртөө тохирсон зөв арга барилаар ажиллах, мэдлэгээ амьдрал орчиндоо тохируулан хувиргаж хэрэглэх зэрэг чадваруудыг эзэмшихэд нь багш суралцагчаа чиглүүлэн өдөөж, хамтран ажиллах нь идэвхтэй сургалтын нэг онцлог мөн.

Сургалтын талаарх идэвхтэй, конструктив үзэл баримтлал нь багшийн үйл ажиллагааны талаарх ойлголтод багагүй өөрчлөлт оруулжээ. Энэ талаар олон судалгаа хийгдсэнээс Вүүд, Кобб (Wood, Cobb, 1992) нарын дүгнэлтийг товч авч үзье. Тэд багшийн үйл ажиллагааг доорх байдлаар тодорхойлжээ:

- Багш нар асуудал дэвшүүлсэн нөхцөлийг суралцагчийн хувьд бүрдүүлэхүйц зааварчлан чиглүүлэх үйл ажиллагаа явуулна.
- Хүүхдийн үйл ажиллагаа нь тэдний хувьд ухаалаг зүйл байдаг учраас багш нар суралцагчийнхаа шийдлийг тэдний байр сууринаас авч үзэхийг хичээх нь чухал
- Орчин үеийн ойлголт төсөөллийн үүднээс аваад үзэхэд хүүхдийн мэдлэг, туршлагын талаарх томчуудын үзэл баримтлалд ямар алдаа байсныг олж харахыг багш нар хичээх нь зүйтэй. Юм мэдэхгүй балчирхан хүүхдэд томчууд бид л бүхнийг зааж сургах ёстой гэж үздэг бидний үзэл зөв үү гэдгийг эргэн харах хэрэгтэй болж байгаа юм.
- Бие даасан сургалт нь энгийн, хялбар зүйл биш. Ийм сургалт маш удаан хугацааны туршид зөрчил, маргаан, мухардал, гэнэтийн тохиолдол эерэг, сөрөг олон нөхцөлийг даван туулах явцад нийгмийн харилцааны хүрээнд явагдаж байдаг. Сургалтын утга учрыг тодорхойлоход нийгмийн харилцаа ба харилцан үйлчлэл нэн чухал гэдгийг багш нар бодитойгоор харгалзах хэрэгтэй.

Өргөжин хуримтлагдах сургалт

Шинэ сургалт нь суралцагчийн хуучин мэдлэг дээр тулгуурлан түүний мэдлэгийн хүрээ улам тэлэх замаар явагдана. Юуг, яаж сурах вэ гэдгийг тодорхойлох нэг гол хүчин зүйл бол хуучин мэдлэг юм. Энэ нь сургалтыг хөнгөвчлөх ба саатуулах нөлөөтэй байдаг. Энэ бол шинэ хуучин мэдлэгийн залгамж холбооны асуудал юм. 70150065 93190092

Суралцагчийн мэдлэг өдөр өдрөөр тэлэн хуримтлагдах ёстой боловч өнөөгийн сургалт энэ шаардлагыг тэр болгон хангаж чадахгүй байгаа билээ. Буруу ойлголт, тодорхойгүй бүрхэг зүйлүүд нь дараагийн шатны мэдлэг эзэмшихэд багагүй бэрхшээл учруулдаг. Буруу ойлголтыг залруулах нь шинэ мэдлэг эзэмшихээс өмнө хийгдэх ёстой. Үүнд багшаас сурагчид туслах туслалцааны нэг чухал тал орших билээ. Жишээ нь “Нисдэг бүхэн бол шувуу”, “Иддэг зүйлийг үр жимс гэнэ”, “Хулчгар хүн буулт хийдэг”, “Буруу зүйлээс ухаалгаар татгалзсанаас тэнэг зүйлийг ч гэсэн зоригтой хийсэн нь дээр” гэх зэрэг буруу ойлголтууд хүүхдэд төлөвшсөн байх нь цөөнгүй. Амьдралын явцад суралцагчдад урсгалаар бий болсон эдгээр “хар ойлголтуудыг” сургалтын явцад задлан шинжилж зөв талыг нь бататган эндүү ташаа хэсгийг залруулах замаар шинжлэх ухааны мэдлэгийн цар хүрээ өргөжин тэлнэ. Идэвхтэй, конструктив шинж бүхий орчин үеийн сургалтын онцлогийг доорх хүснэгтээр харуулав.

Онолын гурван өөр чиг хандлагын үүднээс багшлах ба суралцах үйлийг тодорхойлох нь

Үзүүлэлтүүд	Бихевиорист	Конструктивист	
		Когнитив	Социаль
Суралцах үйл	Баримт, арга барил, үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрөх, эвлэрэх замаар суралцана Дасгал сургуулилалт, дадлагаар сурна Суралцагчид хувиа борлуулах замаар ажиллана Сургалтын үйл явц журамлагдсан, өнгөц шинжтэй	Мэдлэгийг идэвхтэйгээр бүтээх ба хуучин мэдлэгийг шинэчлэн эзэмших замаар хамтран суралцана Шинэ ба хуучин мэдлэгийг холбох төрөл бүрийн боломж, үйл явцаар илэрнэ Бусадтай болон орчинтойгоо харилцан үйлчлэлцэх замаар ажиллана Сургалтын үйл явц гүнзгий, нухацтай,	Нийгмийн хувьд үнэ цэнтэй мэдлэгийг хамтран бүтээх замаар суралцана Нийгмээс бүрдүүлэн бүтээсэн боломж, нөхцөлөөр дамжин илэрнэ Бусадтай болон орчинтойгоо харилцан үйлчлэлцэх замаар явагдана Агуулгыг эзэмших, тайлбарлах буюу харилцан үйлчлэлцэх замаар утга учир, үнэ цэнийг тайлбарлах ажиллана (юуг, яаж эзэмших) олон арга хувилбартай
Багшийн ажиллагаа	Мэдлэгийг өгүүлэн дамжуулах арга голлоно	Илүү сайн ойлгох, сэтгэх эрмэлзсэнийг өдөөх чиглүүлэх арга голлоно	Мэдлэгийг суралцагчидтайгаа хамтран бүтээх арга голлоно
Багшийн үүрэг	Хүүхдийг зааварлагч том хүн Мэдлэгийн үндсэн эх сурвалж Удирдагч, хөтлөгч Товлосон хугацааны Буруу хариултыг залруулах хүн	Ихээхэн дадлага туршлагатай хүн Мэдлэгийн эх сурвалж (Суралцагч, сургалтын материал ба орчны хамтаар) Сурах үйл явцыг хөнгөвчлөн чиглүүлэгч Өөрт нь утга, ач холбогдол бүхий бусадтай хүн харилцан үйлчлэлцэх боломжийг бүрдүүлэгч Суралцагчийнхаа үзэл баримтлал, бүрдүүлэгч төөрөгдлийг нь сонсогч	Дадлага туршлага ихтэй хүн Мэдлэгийн эх сурвалж (Суралцагч, сургалтын материал ба орчин, нийгмийн хүчин зүйлүүдийн хамтаар) Сурах үйл явцыг хөнгөвчлөн, хамтран оролцогч Өөрт нь утга, ач холбогдол бүхий зүйлүүдийг хийх, болон бусадтай харилцан үйлчлэлцэх боломжийг суралцагчидтайгаа хамтран бүрдүүлэгч Мэдлэг ба нийгмийн хувьд чухал үзэл баримтлалыг олон янзаар тайлбарлах боломжийг хамтран бүрдүүлэгч

Үе тэнгийнхний үүрэг	Ихэнх тохиолдолд тодорхойгүй	Үе тэнгийнхний үүрэг зайлшгүй биш, гэхдээ асуулт тавих, ярилцах хэсэг зэргээр сэтгэлгээг эрчимжүүлэх боломжтой	Мэдлэг бүтээх үйл явцын салшгүй хэсэг Мэдлэгээ түгээх, хуваалцах Харилцан бие биедээ туслах үүрэгтэй
Суралцагчийн үүрэг	Мэдлэгийг идэвхгүйгээр хүлээн авах Идэвхтэй сонсогч, заавар хэрэгжүүлэгч Даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэгч, ажилчин	Мэдлэгийг оюун ухаандаа идэвхтэйгээр бүтээгч Мэдлэгийн эх сурвалж (Ганцаараа болон бүлгээрээ) Сэтгэлгээг эрчимжүүлэгч, зохион бүтээгч Идэвхтэй сэтгэн бодогч тайлбарлагч, асуугч Ойлгон ухаарах, асуух, тайлбарлах үүрэгтэй.	Өөрөө бие дааж болон бусадтайгаа идэвхтэйгээр бүтээгч Мэдлэгийн эх сурвалж (Ганцаараа болон бүлгээрээ) Сэтгэлгээг хамтран эрчимжүүлэгч, хамтран зохион бүтээгч Идэвхтэй сэтгэн бодогч, тайлбарлагч, асуугч Ойлгон ухаарах, асуух, тайлбарлах үүрэгтэй

Сургалт бол нийгмийн харилцаа мөн

ЕБС –ийн нэг ангид ойролцоогоор 30 сурагч суралцдаг. Хэдийгээр энэ тоо20—50-ын хооронд хэлбэлзэж байгаа боловч бид энэ удаа анги дүүргэлтийн тухай асуудлыг шүүн хэлэлцэхээсээ илүүгээр ангид явагдаж байгаа нийгэм - сэтгэл зүйн асуудлыг товч хөндөх юм. Суралцагч гэртээ болон сургууль дээрээ ихэнх цагаа өнгөрөөдөг. Цаг хугацаа, нийгэм - сэтгэл зүйн үүднээс энэхүү хоёр бага бүлэг нь суралцагчийн хөгжил төлөвшилд шийдвэрлэх үүрэгтэй юм. Ангид өдөр дутам ямар харилцаа явагдаж байна вэ? гэсэн асуулт нь суралцагчийн нийгэм сэтгэл зүйн туршлагыг тодорхойлоход нэн чухал үүрэгтэй байдаг. Энд нийгэм – соёлын, сэтгэл хөдлөлийн, хүмүүс хоорондын болон хүнээс орчинтойгоо харилцах маш олон талын өвөрмөц харилцаа явагдаж байдаг. Ангид танин мэдэх үйл ажиллагааны зэрэгцээ нийгэм сэтгэл зүйн олон талт харилцаа явагддаг учраас “Сургалт бол нийгмийн харилцаа мөн” гэдгийг онцлон тэмдэглэх болжээ.

Сургалт бол нийгмийн бодот харилцаа мөн

Сургалтын явцад багш суралцагчид хамтран нийгэм, соёлын орчноо бүтээж байдаг. Тэдний хамтран бүтээсэн энэхүү орчин нь нийгмийн харилцааны хэм хэмжээ, үүрэг, хувь хүмүүсийн хоорондын харилцааны цар хүрээ, өөрийн үнэ цэнийн талаарх хувь хүний ойлголт мэдрэмж зэргийг тогтворжуулан бататгахад нэн чухал үүрэг гүйцэтгэдэг.

Ангид явагдаж байгаа нийгэм - сэтгэл зүйн үйл явцыг нийгэм – Хэл шинжлэлийн,соёлын, угсаатан, ёс заншлын талаас гэх зэргээр судлаачид харилцан адилгүй байр сууринаас авч үзсэн байдаг хэдий ч энэ нь нийгмийн олон талт харилцааны эхлэл суурь тавигдахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг гэдгийг ихэнх нь онцлон тэмдэглэсэн байдаг. Сүүлийн жилүүдэд ангид явагдаж байгаа танин мэдэхүйн үйл явцын нийгмийн мөн чанар, ач холбогдол, сэтгэл - хэл шинжлэлийн асуудлуудад судлаачид нэлээд анхаарал хандуулах болсон байна. Эдгээрээс нэгэн социо-лигивистик судалгааны талаар товч өгүүлбэр. Энэхүү судалгааг Жади́ф Грийн,(Judith Green, 1977), Голден, Харкер (Golden81988, Harker, 1988) нар хийсэн байна.Бага ангийн 11 багшийн унших хичээлийн үр дүнг судалжээ. Нэг бүлэгт 7 суралцагч байсан ба унших хичээлээр тэдэнд нэгэн өгүүлэл ярьж өгсөн. Хичээлийн дараа тэрхүү өгүүллийг сэргээн ярихыг хүүхдүүдээс хүссэн. Багш нар заах аргаа чөлөөтэй сонгож авсан бөгөөд энэ талаар ямар нэгэн хязгаарлалт хийгээгүй. Судалгааны хөтөлбөрт хамрагдсан 18 сарын хугацаанд багш бүр уг өгүүллийг ангидаа ярьж өгөхөөр төлөвлөгдсөн байв. Өөрөөр хэлбэл бүх багшийн хичээлийн төлөвлөгөөнд уг өгүүлэл орж өгсөн гэсэн үг. Хичээл дээр уг өгүүллийг уншиж ярилцсаны дараагаар судлаач суралцагч нэг бүртэй ганцаарчлан уулзаж ярилцжээ. Уулзалтынхаа үеэр “Энэ өгүүллийг танай ангийнхнаас хэн нэг нь огт сонсоогүй байна гэж бод. Тэгээд түүнд чи өгүүллийг ярьж өгч байна гэж бодоорой”, гэсэн заавар өгөөд өгүүллийг давтан ярихыг тэднээс хүссэн. Өгүүллийн үйл явцыг дугаарлан оноогоор илэрхийлсэн

ба уг өгүүлэл хэчнээн үйл явцаас бүтэж байсныг хүүхдүүд сэргээн санаж нэрлэх хэрэгтэй байжээ. Багш бүрийн хичээлийн видео бичлэг хийгдсэн байлаа. Эдгээр хичээл болон судалгааны үр дүнд гурван төрлийн анхан шатны анализ хийжээ. Судалгааныхаа анализад тулгуурлан багш нарыг хоёр хэсэгт хуваасан. “G” бүлгийн багш нар. Энэ бүлэгт шавь нар нь дээрх өгүүллийг дахин ярих даалгаврыг маш сайн гүйцэтгэсэн багш нарыг хамруулсан. Харин “S” бүлгийн багш нарын шавь нар уг даалгаврыг тааруухан гүйцэтгэжээ. Энэхүү унших хичээлийн талаар хийгдсэн гурван төрлийн анализ нь гурвуулаа социолингвистик шинжтэй юм гэж судлаачид үзжээ.

Грийн (Green et al., 1988) нарын хийсэн нэг дэх анализын дүнд дээрх хоёр бүлгийн багш нарын үйл ажиллагааны ялгааг дараах байдлаар тодорхойлжээ:

а) “G” болон “S” бүлгийн багш нарын хичээлийн зохион байгуулалт нь ялгаатай байсан: “G” бүлэгт багтсан багш нарын хичээл хоёр, харин “S” бүлгийнх нь дөрвөн үе шаттайгаар тус тус зохион байгуулагдсан байжээ.

б) “G” бүлгийн багш нар “S” бүлгийнхнийг бодвол өөрсдөө хичээл дээ хазайхгүйгээр өгүүллийн агуулгыг илүү өргөн илэрхийлж байгаа нь ажиглагджээ.

в) Хариу мэдээллийг суралцагчдаас авах аргаараа ялгаатай байсан: аль аль нь олон асуулт асууж байсан боловч “G” бүлгийн багш нарын тавьсан асуулт нь нийтэд хүртээмжтэй, Нээлттэй байсан бол “S” бүлгийн багш нарын асуулт цөөн хэдэн суралцагчдад чиглэж байжээ.

г) Энэ хоёр бүлгийн багш нарын тавьж байгаа асуултууд хэв шинж, мөн чанарынхаа хувьд ч ялгаатай байжээ.

Харкерийн (Harker, 1988) хийсэн мэдээлэх түвшний өөр нэг анализ доорх ялгаануудыг гаргасан байна: а) “G” бүлгийн багш нарын хичээл дээр өгүүлэлтэй холбоотой хэлэлцүүлэг” S” бүлгийн багш нараас даруй хоёр дахин илүү хийгдсэн, б) “G” бүлгийн багш нарын хичээл нь сэдэвтэйгээ оновчтой холбогдсон, товч тодорхой байсан, в) багш нарын зүгээс тавьж байсан тодруулах асуултууд нь өөрөөр сэдвүүдийг хөндөж байсан гэжээ.

Голден (Golden, 1988) багшийн заасан болон суралцагчийн давтан ярьсан өгүүллийн агуулгад утга зохиолын талын анализ хийж доорх мэдээлэл өгчээ: а) “G” бүлгийн багш нар нь “S” бүлгийнхнийг бодвол өгүүллийн үйл явдлын дотоод харьцуулалт хийх мэдээллийг түлхүү өгсөн б) мөн өгүүллийн үйл явдлуудын талаарх зэрэгцсэн харьцуулалт хийх боломж нь “G” бүлгийн багш нарын хичээл дээр давуу байсан, в) “G” бүлгийн багш нарын суралцагчид нь өгүүллийн үйл явдлуудыг болон тэдгээрийн элементүүдийг илүү олныг нэрлэж байжээ.

Эдгээр гурван анализ нь харилцан бие биеэ баяжуулж байгаа бөгөөд сургалтын явцад ангид явагдаж байгаа бие хүмүүсийн хоорондын харилцан үйлчлэлийг социолингвистик талаас нь тайлбарлах, судлах боломжийн талаар харьцангуй энгийн бөгөөд шинэлэг мэдээллийг бидэнд өгч байгаа билээ. Зөвхөн энэхүү судалгааны хүрээнд авч үзэхэд сургалтын явцад багшийн зүгээс өдөөн өгч байгаа харилцан яриа, хэлэлцүүлэг нь багшийн хүүрнэл яриа зонхилсон уламжлалт аргаас илүү давуутай бөгөөд сургалтын нийгмийн мөн чанар ч үүнийг шаардаж байгаа болохыг харуулж байна. Багш нь нийгмийн туршлага илүүтэй хүнийхээ хувьд суралцагчдыг идэвхтэй сэтгэн бодох үйл ажиллагаа шаардсан харилцан яриа, хэлэлцүүлэг, маргаанд өдөөн өгөх хэрэгтэй юм. Бодож санаж байгаагаа гадагш нь үгээр оновчтой илэрхийлэх асуудал нь хэл сэтгэхүйн нарийн уялдаа холбоог илэрхийлж байдаг гэдгийг манай багш сурган хүмүүжүүлэгчид Оросын эрдэмтдийн зохиол бүтээлээс сайн мэдэх билээ. Жишээ нь оросын нэрт сэтгэл зүйч Л.С.Выготский дотоод оюуны үйлдэл, дотоод ба гадаад ярианы хоорондын уялдаа холбоо, сэтгэцийн үйлийн гадагшлах ба дотогшлох үйл явцын талаар өөрийнхөө зохиол бүтээлүүдэд онцлон тэмдэглэсэн байдаг.

Энэ бүхнээс үзвэл сургалтын явцад хийгдэх нийгэм - сэтгэл зүйн, тодруулбал нийгмийн танин мэдэхүй, социолингвистик судалгаанууд нь манай багш сурган хүмүүжүүлэгчид, судлаачдын урьд өмнө мэддэг

зүйл дээрээ тулгуурлан шинэлэг үзэл санаагаар баяжуулан хийж чадах зүйл ГЭДЭГ НЬ харагдаж байгаа юм.

Бодот нөхцөлд тохирсон “жинхэнэ сургалт”

Сургалтын талаарх уламжлалт судалгаанууд нь болж өгвөл бүх нөхцөлд тохирох ямар түгээмэл хууль байж болох вэ? гэдгийг олж тогтооход чиглэгдэж байжээ. Өөрөөр хэлбэл бүх нөхцөл байдал ба бүх хичээлүүдийн аль алинд нь тохирч болох түгээмэл хууль, зүй тогтол байж болох юм гэсэн таамаглал нь сургуулиудын сургалтын хөтөлбөрийг адилхан бүтэцтэй, өөрчлөлт багатайгаар удаан оршиход нөлөөлж байсан гэж үздэг. Бид суралцагчдад чухам юуг, ямар хөтөлбөрөөр, яаж олгож байна вэ? гэсэн асуулт судлаачдын өмнө тулгарах болсон. Сургалтын явцад судалж байгаа зүйлүүдээс чухам юуг хэзээ хүүхэд хэрхэн хэрэглэх вэ? гэдэг нь тодорхойгүй байгаагаас үүдэн олон сөрөг үр дагаврууд гарч ирдэг. Энэ асуудлыг судлаачид 1980 аад оны үеэс эхлэн нилээд эрчимтэй судлах болжээ. Үүнд хүн судлаач Лаав (Lave, 1988, 1990), социалингвистикч болон Рисник (Resnick 1987), боловсролын сэтгэл судлаач, Глейсэр (Glaser 1984), Броун (J.S. Brown, 1989) нарын судалгаанууд чухал нөлөө үзүүлжээ.

Ялангуяа Ж.С. Броун нарын судлаачдын үзэж байгаагаар бол өнөөдөр ердийн ангид явагдаж байгаа нийтлэг сургалтууд нь сургуулиас гадуур явагдаж байгаа бодит амьдралаас эрс ялгаатай, бодит амьдралтай уялдаа холбоо муутай байгаа ажээ. Иймээс суралцагчид амьдралдаа хэрэгтэй, бидний хүсэн хүлээж байгаа тэр зүйлүүдийг сургуулиас сурч гарч чадахгүй байгаа бөгөөд сургалтын үр дүнг тооцохдоо ч үүнийг харгалзан үзэхгүй байна. Товчоор хэлэхэд амьдрал дээр хүсэн хүлээж байгаа зүйлийг сургууль олгож чадахгүй байна. (J.S. Brown and et al., 1989).

Бодот нөхцөлд тохирсон “жинхэнэ сургалт”

Бодот нөхцөлд тохирсон, “жинхэнэ сургалтын” үзэл баримтлал ангид өдөр дутам явагдаж байгаа сургалт нь хийсвэр, ач холбогдол багатай ерөнхий зүйлүүдийг биш, харин өдөр тутмын амьдралд тулгарч байгаа танин мэдэхүйн асуудлуудыг шийдвэрлэхийг чухалчилдаг байна.

Броун нарын судлаачид энэхүү үзэл баримтлалаа маш энгийн аргаар илэрхийлэн харуулсан байна. Тухайлбал, ердийн хүмүүс, оюутнууд, практик шинжээчид ямар нэгэн юманд хэрхэн суралцаж эхэлдэг вэ? гэдгийг харьцуулан үзсэн байна. Ердийн хүмүүс болон практик шинжээчид нарын хооронд ямар нэгэн зүйлийг хийж сурахад тохиолддог адил төстэй зүйлүүд олон байхад суралцагчдын суралцах арга барил нь тэднийхээс ялгаатай болох нь ажиглагдсан байна. Практик шинжээчид ба ердийн хүмүүсийн аль аль нь асуудлыг өөрийн амьдарч байгаа соёл орчны хүрээнд, шийдэж болох түвшинд нь авч үздэг бол суралцагчдын хувьд цээжилсэн хууль дүрмийнхээ хүрээнд авч үзэх хандлага голлодог байна. Энэ бол сургалт амьдралаас тасархай явагдаж байгаагийн бодит жишээ мөн гэж үзжээ.

Ердийн хүмүүс, практик шинжээчид, суралцагчдын суралцах үйл ажиллагааны ялгаатай ба төсөөтэй талууд:

Үйл ажиллагаа	Ердийн хүмүүс	Суралцагчид	Практик шинжээчид
Эргэцүүлэл	Учир шалтгааны шатлалыг тунгаан эргэцүүлнэ	Хууль дүрэмд тулгуурлана	Учир шалтгааны загварт тулгуурлана
Үйлдэл	Нөхцөл байдалд тулгуурлан хийгдэнэ	Дүрс тэмдэглэгээнд тулгуурлан хийгдэнэ	Концепчилсэн нөхцөл байдалд тулгуурлан хийгдэнэ
Шийдвэр	Тулгарсан асуудлаар гарна	Тодорхой асуудлаар гарна	Ээдрээтэй, төвөгтэй асуудлаар гарна
Үр дүн	Хэлэлцэж шийдвэрлэж болохуйц, нийгмийн орчинд хүлээн зөвшөөрөгдөхүйц ойлголт, үр дүн гарна	Хатуу, хөдөлгөөнгүй үзэл баримтлал гарна	Хэлэлцэж шийдвэрлэж болохуйц, нийгмийн орчинд хүлээн зөвшөөрөгдөхүйц ойлголт, үр дүн гарна.
Зорилго	Ойлгож мэдрэх	Сайн дүн авах, шат ахих	Ойлгож мэдрэх

Сургалт өнөөгийнх шигээ хэвээрээ байх уу? Эсвэл түүнийг өдөр тутмын амьдралд ойртуулан шинэчлэх үү? Энэ бол нарийн төвөгтэй олон талтай асуудал. Сургалт амьдралд ойр, суралцагчдад хэрэгтэй байх ёстой хэмээн ярих нь хэдийгээр хялбар зүйл боловч шийдвэрлэхэд төвөгтэй олон асуудал тулгарах нь дамжиггүй. Үүний тулд дор хаяад дараах асуудлуудад хариу өгсөн байх шаардлагатай.

1. Хэрвээ сургалт хүний амьдралын ердийн орчинд болон хүмүүс хоорондын өдөр тутмын харилцааны явцад явагдаж болно гэж үзвэл сургалт ба мэдлэгийн мөн чанар ямар байх вэ? Зөвхөн л хувь хүмүүсийн ойд хадгалагдан үлдсэн үлдэгдлээр мэдлэгийн мөн чанарыг тодорхойлох уу?
2. Хэрвээ бүх мэдлэгийг тодорхой нөхцөл байдалд тохируулан олговол хувь хүмүүс өөр өөр нөхцөлд түүнийг хэрхэн хэрэглэх вэ? Хоорондоо ялгаатай нөхцөлүүдийг холбох нийтлэг зүйлийг хэрхэн тодорхойлох вэ?
3. Бусад хүмүүсийн аль хэдийн нээж тодорхойлсон зүйлийг дундажлан заадаг сургалт ба бодит нөхцөлд тохируулан явуулах сургалт хоёр хоорондоо ямар холбоотой байх вэ? гэх зэрэг олон асуултуудад хариулах шаардлага тулгарч байгаа билээ.

Сургалтын энэхүү үзэл баримтлалыг боловсролын сэтгэл зүйчид сонирхон судалсаар байгаа юм. Жишээ нь, Коллинс (Collins, 1990) бодит байдалд нийцсэн “жинхэнэ сургалт”-ын ач холбогдлыг ийнхүү тодорхойлсон байна: "Бодит байдалд нийцсэн жинхэнэ сургалт нь а) Хэрэглээний мэдлэг эзэмших нөхцөл бий болох; б) бүтээлч хандахад тус дөхөм үзүүлэх, в) суралцагчид эзэмшиж байгаа мэдлэгийнхээ цаад утга, ач холбогдлыг олж харах; г) хэрэглэхэд тохиромжтой зэрэг давуу талуудтай юм" (A.Collins, 1990, 122-123) гэжээ.

Эцэст нь нэмж хэлэхэд хүн бүрт хүртээмжтэй байх иймэрхүү танин мэдэх үйл ажиллагааг бүлгээр болон нүүр тулан ганцаарчилж ажиллах хэлбэрээр явуулах боломжтой гэдгийг өгүүлэх нь зүйтэй юм. Ганцаарчлан ажиллах энгийн хэлбэр нь эцэг эх нь хүүхдэдээ мэдэхгүй зүйлийг тайлбарлан хэлэх замаар заан сургахтай адил ажээ.

Багшлах үйл ажиллагаа

Розенцайн, Стивенс нар багш нарын үйл ажиллагааны үр дүнгийн талаар хийсэн олон судалгааг нэгтгэн дүгнэсний үндсэн дээр “Багшийн хийж гүйцэтгэх зургаан үйл ажиллагаа” гэж нэрлэн доорх байдлаар тодорхойлжээ. Багшийн зургаан үйл ажиллагаа (Six teaching functions)

1. Өдөр тутмын хяналт ба гэрийн даалгавар шалгах

- Гэрийн даалгавар шалгах (Суралцагчид бие биеийнхээ даалгаврыг харилцан шалгах журам байж болно)
- Шаардлагатай бол дахин зааж тайлбарлах
- Өнгөрсөн хичээлтэй холбоотой зүйлийг эргэн тоймлох (асуулт хариултын хэлбэртэй байж болно)
- Арга барил эзэмших урьтал нөхцөл бүрэлдсэн эсэхийг тоймлох (Хэрэв ийм боломжтой бол)

2. Илтгэх (заах) ажиллагаа

- Зорилгоо товч тодорхойлох
- Агуулгын тойм ба бүтцээ тодорхойлох
- Алхам алхмаар түргэн хурдацтай явах
- Ойлголт шалгах асуулт тавих
- Гол асуудлаа онцлон тэмдэглэх

- Үзүүлэн таниулах материал болон жишээ баримтыг хангалттай гаргах
- Загвар, сурталчилгаа хэрэглэх
- Шаардлагатай үед илүү нарийвчилсан нэмэлт зааварчилга, нэмэлт жишээнүүд өгөх

3. Багшийн удирдлагаар хийх дадлага

- Суралцагчийн анхан шатны дадлага нь багшийн удирдлагаар явагдана
- Багшаас олон дахин асуух, сургалтын материалаас эргэн лавлах замаар суралцагч дадлага хийнэ
- Асуулт нь шинээр эзэмших арга барил ба шинэ агуулгатай шууд холбоотой байна
- Суралцагчийн хариу үйлдэлд үнэлгээ өгөх замаар ойлголтод хяналт тавина
- Ойлголтыг хянах явцдаа багш шаардлагатай бол нэмэлт тайлбар өгч дахин хариу мэдээлэл авч болно
- Ойлголтыг хянах явцад сурагч бүр идэвхтэй оролцон хариу мэдээлэл өгөх боломжоор хангагдсан байх нь чухал
- Багшийн удирдлагаар явуулж байгаа дадлага шуурхай, эрчимтэй байна (Зөв зохистой байна) Цаашдаа бие даан ажиллахад хангалттай бэлтгэл болохуйц түвшинд энэ дадлага хийгдсэн байна
- Суралцагч бие даан дадлага хийх боломж найдвартай бүрдлээ гэж үзэх хүртэл энэ дадлага үргэлжилнэ
- 80% -ийн амжилт үзүүлэх хүртэл энэ дадлага үргэлжилнэ

4. Залруулга ба хариу үйлдэл

- Суралцагчийн хийж байгаа зүйл зөв гэдгийг баталсан богино хугацааны товч бататгал ба урамшуулал нь араасаа өөр асуултыг дагуулж байж болно. (“Зүйтэй” г, м)
- Зөв атлаа түдгэлзсэн хариултауд нь араасаа суралцагчийн хариу үйлдлийг дагуулж байж болно. (ТиймЭэ, Туяа ЭНЭ ЗӨВ Л ДӨӨ, ГЭХДЭЭ ГЭХ МЭТ)
- Суралцагчийн гаргаж байгаа алдаа бол дадлага хийх хэрэгцээг харуулж байгаа үзүүлэлт гэдгийг ойлгох
- Суралцагчдын байнга гаргаж байгаа алдаануудад дүн шинжилгээ хийж үзэх
- Асуулт бүрт тохирох гол хариултыг олохыг хичээх
- Залруулга нь хариу мэдээлэл авах, (асуултыг хялбарчлах, санаа авах сэжиг гаргаж өгөх Г.м) алхмуудыг эргэж тайлбарлах, эргэн тоймлох, хариу мэдээллийг дахин авах, өнгөрснөө дахин заах зэрэг олон идэвхтэй үйл ажиллагааг агуулж байж болно
- Суралцагч эхний ойлголт буруу байсан бол дараагийнх нь зөв болж сайжирсан эсэхийг асууж тодруулахыг хичээх
- Багшийн удирдлагаар хийх дадлага, ба залруулах үйл ажиллагаа нь тухайн ангийнхан дараагийн хичээлийн зорилгыг хүлээн авахад бэлэн боллоо гэж үзэх хүртэл үргэлжилнэ.
- Суралцагчийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэсэн оновчтой магтаалыг явц дунд хийх нь эцсийн ерөнхий магтаалаас чухал гэдгийг анхаарах

5. Бие даан гүйцэтгэх дадлага (гэрийн даалгавар, оришин суугаа газраа хийх дадлага)

- Дадлагыг хангалттай хийх
- Хичээлээр үзсэн зүйл болон холбогдох арга барилыг эзэмшихэд дадлага шууд чиглэгдсэн байх
- Баттай суралцахын тулд дадлага хийх
- Хариу үйлдлийг баттай, түргэн автомат шинжтэй болтол дадлага хийх
- Бие даасан дадлагын явцад хийвэл зохих зүйлийн 85% -ИЙГ ЗӨВ хийж чаддаг болсон байх
- Бие даан хийсэн дадлагаа шалгуулахад суралцагчид бэлэн болсон байх
- Боломжтой үед оюутнуудад зориулсан мэргэжлийн зөвлөгөө зохион байгуулах

6. Долоо хоногийн болон сарын хяналт

- Заасан зүйлээ тогтмол эргэн хянадаг байх
- Үүнд гэрийн даалгавар багтана
- Тест тогтмол авч байх
- Тестийн явцад илрүүлсэн алдааг залруулах, дахин заах

Эх материал: “Teaching Functions” by B.Rosenshine and Stevens, 1986, in M.C.Wittrock (Ed.), Handbook of research on teaching (3rd.,ed p. 379), New York: Macmilian

Розеншайн, Стивенс нарын нэгтгэн боловсруулсан багшийн үйл ажиллагааны энэхүү журам нь ерөнхийдөө суралцагчийн эзэмшсэн онолын мэдлэгийг дадлагаар бататгахад чиглэгджээ.

Суралцах үйл ажиллагаа

Багшлах ба суралцах үйл ажиллагаа нягт уялдаатай явагддаг хэдий ч хоорондоо ялгаатай гэж үздэг. Энэ нь сургалтын явцад багш ба суралцагчийн гүйцэтгэж байгаа үүргүүдтэй холбоотой. Суралцах үйл ажиллагаа сэтгэл зүйн зарчим, зүй тогтлуудад илүү тулгуурладаг бол багшлах үйл ажиллагаа сурган хүмүүжүүлэх ажлын үр дүн, туршлагад илүү тулгуурладаг гэж зарим судлаачид үздэг. (Shuell, 1988, 1992). Суралцах үйлийн талаар Шуйллийн санал болгож байгаа загвар багшлах үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, суралцах үйлийг зөв төлөвлөхөд ач холбогдол бүхий хоёр чухал санааг агуулснаараа онцлог юм. **Нэгдүгээрт**, Суралцах үйлийн бүрэлдэхүүн хэсэг бүрт тохирсон, үр дүнтэй аргыг хэрэглэх боломжтой гэж үздэг. Судлах зүйлийн агуулга, тухайн ангид суралцаж байгаа сурагчдын онцлог зэрэг олон хүчин зүйл суралцах үйлийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг гүйцэтгэх арга, замыг сонгон авахад нөлөөлөх ажээ.Өөрөөр хэлбэл сургалт явагдаж байгаа тухайн тодорхой нөхцөлөөс шалтгаална гэсэн үг. Жишээ нь анхаарлыг төвлөрүүлэх ямар арга техникийг хэрэглэж болох вэ?Суралцагч ном сурах бичиг, сургалтын материалтай ажиллаж байгаа бол гарчгийг томоор буюу тодруулан бичих, зураг диаграмм ашиглах, тусгайлан зурж тэмдэглэх зэрэг аргууд тохиромжтой. Хэрвээ багш суралцагчид харилцан ярилцах боломжтой байгаа бол тухайн сэдвийн ач холбогдлыг үгээр онцлон тэмдэглэх, тайлбарлах аргууд хэрэглэж болно. Товчоор хэлбэл суралцах үйлийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрт тохирох аргыг сонгон авахад сургалт явагдаж байгаа бодит нөхцөлийг харгалзах хэрэгтэй юм. Бидний авсан жишээнээс үзэхэд анхаарлыг яаж төвлөрүүлсэн нь биш харин түүнийг төвлөрүүлж чадсан эсэх нь чухал юм. **Хоёрдугаарт**, суралцах үйл багш ба суралцагчийн аль алиных нь санаачилгад тулгуурласан байж болно гэж үздэгт Шуйллийн загварын өөр нэг ач холбогдол оршдог. (Зөвхөн багш төдийгүй ном сурах бичиг, компьютер зэрэг сургалтын зааварчилгааг агуулсан төрөл бүрийн материал хэрэгслэлүүд суралцах үйлийг хэрхэн гүйцэтгэх арга замуудыг илэрхийлж болно гэж үздэг. Түүний энэ санаа багшлах ба суралцах үйлийн холбоо, хамаарлыг онцлон тэмдэглэж өгдөг байна.

Орчин үеийн сэтгэл судлалын шинжлэх ухааны үүднээс багшлах ба суралцах үйлийг үр дүнтэй явуулахад зайлшгүй чухал гэж үзэж байгаа суралцах үйлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг доорх хүснэгтээс

харж болох юм. Багш ба суралцагчийн хэнийх нь санаачилгад тулгуурласнаас ямар үйлийг ямар аргаар гүйцэтгэх нь шалтгаалах ажээ.

Суралцах үйл ажиллагааг явуулахад суралцагч ба багшийн зүгээс хэрэглэж болох арга барилуудыг харуулсан жишээнүүд

Үйл ажиллагаа	Багшийн санаачилгад тулгуурласан	Суралцагчийн санаачилгад тулгуурласан
Хүсэж хүлээгдэж байгаа зүйлүүд	Хичээлийн зорилго ба зорилтоо тодорхойлох, судлах материалыг тоймлоно.	Өөрөө хийхээр товлосон төсөл, гэрийн даалгавар, унших зүйл зэрэгт тохируулан зорилгоо тодорхойлно.
Сэдэл	Туршлага, мэдлэгээ харилцан солилцох, сонирхолтой материал ашиглах боломжийг бүрдүүлнэ.	Хувь хүнд өөрт нь хамаатай төсөл, хичээл, болон бусад зүйлүүдийг хийх.арга замуудыг эрнэ.
Өмнөх мэдлэгийг сэргээх	Шинэ МЭДЭЭЛЭЛ хүлээн авахад урьтал нөхцөл болохуйц мэдлэгийг өмнөх хичээлээс сэргээн сануулахад багш анхаарна.	Энэ сэдвийн талаар би өмнө нь юу мэдэж байсан, одоо хийхээр товлосон зүйл чухам ямар мэдээлэл шаардаж байна гэдгийг өөрөөсөө асууна.
Анхаарал төвлөрүүлэх	Чухал зүйлийг онцлон тэмдэглэх ба үгээр тодруулах аргыг багш хэрэглэнэ.	Гол асуудал, түлхүүр ухагдахуун зэргийг өөрөө онцлон тэмдэглэнэ.
Мэдээллийг кодлох	Диаграмм, олон талт жишээ, төрөл бүрийн нөхцөлүүд өгөх, мнемотехникүүд санал болгох зэргээр ажиллана.	Суралцагч өөрөө олон хувилбарт нөхцөлд тохирох жишээ гаргах, мнемотехник, дүрслэл зураглал гарах, зохиох зэргээр ажиллана.
Харьцуулах	Асуулт, диаграмм, график зэргийг ашиглах замаар харьцуулалтыг өдөөж өгнө.	Судалж байгаа материалынхаа төсөөтэй ба ялгаатай талуудыг тодорхойлох зураг диаграмм ашиглах зэргээр эрж хайна.
Таамаглал гаргах	“Хэрэв... бол?” гэх зэргээр асуулт тавьж тухайн зүйлийн талаарх алтернатив хувилбаруудын талаар бодоход суралцагчдыг өдөөж өгнө.	Боломжит хувилбарууд, дүйцэх шийдлүүдийг суралцагч гаргаж ирнэ.
Дасгал дадлага хийх	Багшийн удирдлагаар дадлага хийх, хариу үйлдэл хийх, олон талт жишээ баримтлан дээр ажиллах.	Судалж байгаа зүйлээ тогтмол эргэн хянаж нягтлах, дадлага хийж үзэх зэргээр ажиллана.
Хариу мэдээлэл	Тусгай заавар, журмын дагуу шалгах ба хариу мэдээлэл авч залруулга хийнэ	Өөрөө төрөл бүрийн асуултуудыг дэвшүүлэн тавьж хариултыг эрж хайна
Үнэлгээ	Хариу мэдээллийг чухалчлах ба сурлагын амжилтаа үнэлж дүгнэхэд нь тэднийг өдөөж өгнө.	Чухам юу судалж байгаагаа би мэдэж байна уу?” “Юуг мэдэх шаардлага хэрэгцээ надад тулгарч байна?” гэх зэргээр өөрөөсөө асууна.
Дүгнэлт	Ойлголтыг нягтлах үүднээс үнэлгээ хийгдэнэ.	Ололтоо нягтлах, өөрөө өөрийгөө шалгах тест авах
Нэгтгэж дүгнэх, цогцолбор болгох	Мэдээллийг нэгтгэн нийлүүлэх арга замуудыг санал болгоно.	Төрөл бүрийн ангилал категори хийх чадвар тогтворжин, хүснэгт зохиож эрэмбэлэх ба юмсын хоорондын өндөр зэрэглэлийн харилцаа холбоог сонирхон эрнэ.

Багшлах ба суралцах үзэл баримтлалын шинэчлэлийн асуудлыг онол арга зүйнүүдээс тоймлон авч үзэхийн тулд хүний зан үйлийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд,тэдгээрийн хоорондын уялдаа холбоо, суралцагчийн сэтгэл зүйн хувийн онцлог,насны ялгаа зэрэг олон чухал асуудлыг орчин үеийн боловсролын сэтгэл судлалын хүрээнд хийгдэж байгаа онолын болон практик судалгаануудад тулгуурлан авч үзэх шаардлага бидний өмнө тулгарч байгаа юм. Эдгээр асуудлыг бид цаашдын бүтээлүүддээ тодорхой эрэмбэ дарааллын дагуу авч үзэх болно.

Харьцуулан судалсан материалууд

1. Мягмар. О. Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд, УБ, 2000.
2. Мягмар. О. Насанд хүрэгчдийн сургалтын сэтгэл зүйн үндэс, УБ, 2006.
3. David C. Berliner & Robert C. Calfee, Hahdbook of educational psychology, New York, 1996.
4. Robert D.Strom, Harold W. Bernard, Educational psychology, California, 1982.
5. Thomas L.Good, Jere E. Brophy, Educational psychology, New York& London, 1986.